

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРТ  
2013 ОНД УЛААНБААТАР ХОТООС ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ  
ШИНЭЧИЛСЭН ЖУРАМ<sup>1 2</sup>**

**1. Ерөнхий зүйл**

1.1. МУИС-ийн бакалаврын хөтөлбөрт 2013 онд Улаанбаатар хотоос оюутан элсүүлэхэд БШУ-ы сайдын 2013 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн А/79 тоот тушаалаар баталсан дээд боловсролын сургалтын байгууллагад “Оюутан элсүүлэх журам” болон энэхүү журмыг баримтална.

1.2. МУИС-д элсэхээр бүртгүүлэгч, элсэгч болон элсэлтийн комиссын үйл ажиллагааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

1.3. МУИС-ийн бакалаврын хөтөлбөрт элсэхээр хүсэлт гаргасан иргэнийг “бүртгүүлэгч”, зохих болзол хангаж элсэлтийн хяналтын тоонд багтсан бүртгүүлэгчийг “элсэгч”, элсэлтийн цахим бүртгэлийн системийг “систем” гэнэ. Элсэлтийн үйл ажиллагааг нэгдсэн байдлаар зохион байгуулахаар томилогдсон комиссыг “элсэлтийн комисс”, элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахад оролцох ажилтныг “комиссын гишүүн” гэнэ.

1.4. МУИС-ийн бакалаврын хөтөлбөрт нийслэл хот болон аймгуудаас элсүүлэх оюутны хяналтын тоог БШУЯ тогтооно.

1.5. Бүртгүүлэгч бүртгүүлэхээс өмнө энэ журамтай танилцах үүрэгтэй.

1.6. Энэхүү журам болон нэмэлт мэдээллийг <http://burtgel.num.edu.mn/docs/> цахим хуудсанд байрлуулна.

1.7. Элсэлтийн комиссын хаяг, элсэлт авах хөтөлбөр, хуваарь сонгуулах өдөр, цаг, байр болон бусад мэдээллийг Боловсролын үнэлгээний төвөөс ЕШ-ын дүн, оноо, жагсаалтыг зарламагц МУИС-ийн төв байрны гаднах электрон самбар болон систем, [www.num.edu.mn](http://www.num.edu.mn) цахим хуудсанд байрлуулна.

1.8. Бакалаврын зэрэгтэй иргэнийг зарим мэргэжлээр бакалаврын орой, эчнээ хөтөлбөрт элсүүлэн суралцуулах ба бүртгүүлэгчдээс элсэлтийн Ерөнхий шалгалт (ЕШ) өгсөн байхыг шаардахгүй. Элсэлтийг “МУИС-ийн бакалаврын орой, эчнээ хөтөлбөрт 2013 онд оюутан элсүүлэх журам”-аар тусад нь зохион байгуулна. <http://burtgel.num.edu.mn/docs/> цахим хуудас руу хандан журамтай танилцаж болно.

1.9. Бакалаврын зэрэгтэй иргэн өдрийн хөтөлбөрөөр суралцаж, бакалаврын боловсрол эзэмших хүсэлтэй бол ЕШ өгсөн байна.

1.10. МУИС-д элсэхийг хүссэн гадаадын харьяат иргэдийн асуудлыг “МУИС-д гадаадын иргэнийг элсүүлэн суралцуулах журам”-аар зохицуулна.

1.11. Энэхүү журмаар зохицуулагдахгүй асуудал гарвал МУИС-ийн захирлын тушаалаар байгуулагдсан Элсэлтийн комисс шийдвэрлэнэ.

**2. Бүртгүүлэгчдэд тавих шаардлага**

2.1. Улаанбаатар хотоос оюутан элсүүлэх хуваарь дээр нийслэл хотод Ерөнхий боловсролын сургууль (ЕБС) төгссөн болон байнга оршин суугаа иргэн өрсөлдөх эрхтэй.

<sup>1</sup>МУИС-ийн Захирлын 2013 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 47 тоот тушаалаар батлагдсан журмыг шинэчилэн батлав.

<sup>2</sup>МУИС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрт аймаг, орон нутгаас оюутан элсүүлэх ажлыг “Аймаг, орон нутгаас Монголын их дээд сургуулиудын консорциум (МИДСК)-ын гишүүн их дээд сургууль, коллежид 2013 онд оюутан элсүүлэх журам”-ын дагуу МИДСК зохион байгуулна.

БШУЯ-наас Багануур дүүрэгт МУИС-ийн бакалаврын хөтөлбөрт оюутан элсүүлэх хяналтын тоог тусад нь баталсан тул энэ дүүрэгт ЕБС төгсөгчид Улаанбаатар хотоос оюутан элсүүлэх хуваарь дээр өрсөлдөх эрхгүй.

2.2. Бүртгүүлэгч элсэхийг хүссэн хөтөлбөр/бүлэг хөтөлбөрт элсэхэд шаардлагатай хичээлээр 2012 эсвэл 2013 онд ЕШ өгсөн байна. Шалгалт өгөх хичээлүүдийг хавсралтад заав.

2.3. Бүртгүүлэгч ЕШ-ын оноог ахиулах зорилгоор 2013 онд ЕШ дахин өгсөн тохиолдолд илүү оноотой зөвхөн нэг батламжаар бүртгүүлнэ.

2.4. Бүртгүүлэгч МУИС-д бүртгүүлэхээс өмнө ЕШ-ын шалгуулагчийн буланд нэвтэрч өөрийн хувийн мэдээлэл болон дүнтэй танилцаж, хэрэв асуудал байвал шийдвэрлүүлсэн байх шаардлагатай.

2.5. Зарим хөтөлбөрийн онцлогоос хамаарч бүртгүүлэгч энэ журмын 4.5-д заасан ур чадварын нэмэлт шалгалт өгнө. Нэмэлт шалгалтын хуваарийг бүртгэх үед мэдэгдэнэ.

2.6. Бүртгүүлэгч ЕШ-д 60-аас доошгүй хувийн (560) хэмжээст оноо авч МУИС-д бүртгүүлэхэд тавигдах минимум шаардлагыг хангасан байх ёстой ба хөтөлбөр/бүлэг хөтөлбөрүүдийн хувьд бүртгэлийн босго оноо ялгаатай байна (Хавсралт).

2.7. Гадаад оронд ерөнхий боловсрол эзэмшсэн, МУИС-д элсэх хүсэлтэй Монгол улсын иргэн элсэлтийн ЕШ-ын журамд заасны дагуу ЕШ өгч, бусад бүртгүүлэгчийн адил бүртгүүлж, элсэнэ.

2.8. Бүртгэлтэй холбоотой төлбөр, тооцоог цахим хэлбэрээр хийнэ.

2.9. Бүртгүүлэгч нь элсэлтэй холбоотой мэдээллийг SMS-ээр хүлээн авах гар утасны дугаар, цахим шуудангийн хаягийг бүртгүүлнэ.

### **3. Элсэлтийн бүртгэл**

3.1. Элсэлтийн бүртгэлийг зөвхөн цахим хэлбэрээр <http://burtgel.num.edu.mn> хаягаар явуулна.

3.2. Бүртгэл 2013 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн 9.00 цагт эхэлж, 7 дугаар сарын 5-ны өдрийн 16.00 цагт дуусна.

3.3. Бүртгүүлэгч системд ЕШ-ын бүртгэлийн дугаар, нууц үгээ оруулснаар элсэх хүсэлтээ гаргана.

3.4. Системд амжилттай нэвтэрсэн үед системээс бүртгүүлэгчийн хувийн болон ЕШ-ын мэдээллийг дэлгэцэнд харуулах ба асуудал гарвал Элсэлтийн комисс юмуу Боловсролын үнэлгээний төвд хандаж шийдвэрлүүлнэ.

3.5. Хувийн мэдээллийг баталгаажуулсны дараа шаардлага хангаж байгаа хөтөлбөр/бүлэг хөтөлбөрийн жагсаалтыг системээс харуулах бөгөөд сонирхсон хөтөлбөрийнхөө талаарх дэлгэрэнгүй мэдээллийг авах боломжтой.

3.6. Бүртгүүлэгч хэдэн ч хөтөлбөрт бүртгүүлж болно. Хөтөлбөр бүрийн бүртгэлийн хураамж 2000 төгрөг, ижил суурьтай бүлэг хөтөлбөрийн бүртгэлийн хураамж 6000 төгрөг, ур чадварын шалгалтын хураамж 4000 төгрөг байна.

3.7. Бүртгүүлэгч бүртгүүлэхийг хүссэн хөтөлбөрийг сонгосон үед төлбөл зохих нийт төлбөрийн хэмжээ гарах бөгөөд уг мэдээлэлтэй танилцаад төлбөрийг цахим хэлбэрээр хийнэ.

### **4. Элсэгчийг шалгаруулах ба мэдэгдэх**

4.1. 2013 оны улсын олимпиадад I-III байрт шалгарсан сурагчийг тухайн чиглэлээр БШУЯ-ны шийдвэрээр шууд элсүүлнэ.

4.2. Олон улсын олимпиадад шагналт байр эзэлсэн, байгалийн ухааны чиглэлээр улсын олимпиадад аймаг, хотоос шалгаран оролцож, МУИС-д бүртгүүлэхэд тавигдах минимум шаардлагыг (ЕШ-ын хэмжээст оноо: 560) хангасан ЕБС төгсөгчийг онооны дараалал харгалзахгүй тухайн чиглэлээр хяналтын тоонд багтаан элсүүлнэ. Ийм элсэгч энэ журмын 3.2-т заасан хугацаанд багтаан Элсэлтийн комисст хүсэлтээ гаргасан байх шаардлагатай.

4.3. МУИС-ийн харьяа гүнзгийрүүлсэн сургалттай “Байгаль-Эх” ахлах сургуулийг төгсөгч бүртгэлийн босгыг хангасан нөхцөлд хяналтын тоонд багтаан мэргэжлийн чиглэлээр нь элсүүлнэ.

4.4. Бүртгүүлэгчийн нийт оноог хавсралтад заасан шалгалтуудын харьцааг харгалзан тооцож гаргана. Тухайлбал, хөтөлбөр хоёр шалгалттай бол хоёр шалгалтын оноог 70:30 харьцаагаар нэмнэ. Өөрөөр хэлбэл, I шалгалтанд авсан оноог 0.7-оор, II шалгалтанд авсан оноог 0.3-аар үржүүлж нэмнэ.

4.5. Дараах хөтөлбөрүүдээр ур чадварын нэмэлт шалгалт авна. Үүнд:

- Компьютерийн график дизайн, Реклам сурталчилгааны менежмент хөтөлбөрт элсэгчдээс хар зургийн шалгалт
- Утга зохиол судлал шүүмж, Урлаг судлал, Сэтгүүл зүй хөтөлбөрт элсэгчдээс бичлэгийн ур чадварын шалгалт.

Нэмэлт шалгалтын оноог Компьютерийн график дизайн, Реклам сурталчилгааны менежмент, Утга зохиол судлал шүүмж, Урлаг судлал хөтөлбөрийн хувьд 70:30, Сэтгүүл зүй хөтөлбөрийн хувьд 40:30:30 харьцаагаар нэмж тооцно.

Ур чадварын шалгалтыг 2013 оны 7 дугаар сарын 5-ний өдрийн 16.00 цагт авах ба (шалгалт авах байр, танхимыг бүртгэлийн үед мэдэгдэнэ) шалгалтын дүн бүхий онооны жагсаалт мөн өдрийн 20.00 цагт гарч, системд орсон байна.

4.6. Хэмжээст оноо тэнцсэн тохиолдолд гүйцэтгэлийн хувиар байр эзлүүлж хуваарь олгох ба гүйцэтгэлийн хувь тэнцвэл боловсролын гэрчилгээний дундаж оноог харгалзана.

4.7. Хяналтын тоонд багтсан эсэхийг бүртгэл хаагдсаны дараа тогтоосон хугацаанд системээр бүртгүүлэгчид мэдэгдэнэ.

## **5. Элсэх эрх олгох**

5.1. Хуваарь сонголт нэг өдөр үргэлжилнэ. Хуваарь сонгуулах өдрийн 09:00-13:00 цагийн хооронд хяналтын тоонд багтсан бүртгүүлэгчдэд элсэх эрх олгоно. Хяналтын тоонд багтсан ч өөр хөтөлбөр сонгосон хүнийг жагсаалтаас хасах бөгөөд дараагийн хүнд хяналтын тоонд багтсан гэсэн мэдэгдлийг SMS-ээр илгээнэ.

5.2. 13:00 цагаас хойш хуваарь үлдвэл мөн өдрийн зарласан цагт бүртгүүлэгч өөрийн биеэр ирж онооныхоо жагсаалтын дарааллаар хуваарь сонгоно. Зарласан цагт нэрийг нь дуудахад байхгүй бол онооны дарааллаар дараагийн хүнд сонголтыг шилжүүлнэ. Хуваарь сонгох үед хоцорсон бүртгүүлэгч ирсэн даруй үлдсэн хуваариас онооны дарааллаар сонгох эрхтэй.

5.3. Бүртгүүлэгч хуваарь сонгохдоо дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:

- i. Иргэний үнэмлэх эсвэл түүнтэй адилтгах баримт бичиг (төрсний гэрчилгээ, гадаад паспорт) хуулбарын (ар, өвөр тал нэг нүүрэнд) хамт
- ii. Бүрэн дунд боловсролын гэрчилгээ (хэрэв түүнээс дээш шатны боловсрол эзэмшсэн бол гэрчлэх баримт бичиг)
- iii. ЕШ-ын батламж, хуулбарын хамт
- iv. Цээж зураг 2 хувь, оюутны үнэмлэхний шаардлагад нийцсэн цээж зураг файл хэлбэрээр (аль аль нь сүүлийн 3 сард авахуулсан байх)

Эдгээр материалыг битүүмжлэл сайтай хавтсанд хийсэн байна.

5.4. Элсэх эрх олгох үед бүртгэлийн мэдээллийг эх бичиг баримтуудтай нь тулгаж баталгаажуулна.

## **6. Бусад**

6.1. Элсэгч хуваарь буцаах тохиолдолд нэг багц цагийн үнэлгээний хэмжээний төлбөр төлнө.

6.2. Нэг хөтөлбөрөөс нөгөө хөтөлбөрт шилжүүлэн элсүүлэхгүй ба хуваарийг бусдад шилжүүлэхийг хориглоно.

6.3. Элсэх эрх авсан элсэгчийг 2013 оны 8 дугаар сарын 19-22-ны өдрүүдэд ажлын цагаар бүрэлдэхүүний сургуулиудын Сургалтын алба бүртгэнэ. Элсэгч энэ хугацаанд

бүртгүүлж, суралцах гэрээ байгуулан, эхний улирлын хичээлээ сонгож сургалтын төлбөр төлсний дараа элссэн тушаалыг гаргана.

6.4. Элсэх эрх авсан боловч заасан хугацаанд ирж бүртгүүлээгүй хүнийг суралцахаас татгалзсан гэж үзэн суралцах эрхийн бичгийг хүчингүйд тооцно.

6.5. Хот, хөдөөгийн элсэлтийн дүн мэдээ гарч, элсэх эрхтэй элсэгчид бүртгүүлсний дараа оюутан элсүүлэх хяналтын тооноос хуваарь үлдвэл (үлдсэн хуваарийг <http://burtgel.num.edu.mn> хаягаар орж харна уу) нөхөж элсүүлэх элсэлтийн бүртгэлийг 2013 оны 8 дугаар сарын 24-25-ны өдөр цахим хэлбэрээр <http://burtgel.num.edu.mn> хаягаар явуулна. Бүртгүүлэгч энэ журмын 2.2-2.9-т заасан шаардлагыг хангасан байх ба бүртгүүлэхдээ журмын 3.3-3.7-д заасны дагуу бүртгүүлнэ. Нөхөн элсүүлэх элсэлтийн тухайд хот, хөдөөгийн иргэдийн аль аль нь өрсөлдөх эрхтэй.

Хуваарь сонголт 8 дугаар сарын 26-ны өдөр энэхүү журмын 5-д заасан цагт, ижил зарчмаар явагдана. Элсэх эрх авсан элсэгч 8 дугаар сарын 27-30-ны өдөр суралцах гэрээ байгуулан, эхний улирлын хичээлээ сонгож сургалтын төлбөр төлснөөр элссэн тушаалыг нь гаргана.

6.6. Элсэлттэй холбоотой бичиг баримтыг хуурамчаар үйлдсэн хүнийг МУИС-д элсүүлэхгүй, элссэн тохиолдолд хасна.

6.7. Элсэлтийг цахим хэлбэрээр явуулахад зориулсан цахим хуудас нь бүтэн жилийн турш тогтмол ажиллагаатай байж, элсэлтийн талаарх мэдээллээр бүртгүүлэгчдийг хангана.

6.8. Цахим бүртгэл явагдаж байх үед МУИС-ийн бүрэлдэхүүн сургуулиуд хөтөлбөрүүдээ танилцуулах, зөвлөгөө өгөх үйл ажиллагааг утас, мессенжер болон цахим шуудангаар зохион байгуулна.

**МУИС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрт 2013 онд  
Улаанбаатар хотоос оюутан элсүүлэх хөтөлбөр/бүлэг хөтөлбөр,  
бүртгэлийн босго оноо, өгсөн байх ЕШ, нийт оноонд эзлэх харьцаа**

Бүлэг	Хөтөлбөр	Босго оноо	Элсэлтийн шалгалт	
			I - 70%	II – 30%
1	<b>Математик</b> ( <i>Математик; Математик, хэрэглээний; Эдийн засаг-математик загварчлал; Статистик, хэрэглээний</i> ) <sup>3</sup> ; <b>Багш, математикийн; Математик, програм хангамж</b>	620	Математик	
2	<b>Компьютерийн ухаан</b> ( <i>Мэдээллийн систем; Менежмент, мэдээллийн системийн; Компьютерийн програм хангамж</i> ) <sup>3</sup>	640		
3	<b>Мэдээллийн технологи; Компьютерийн график-дизайн</b> <sup>1</sup> ; <b>Компьютерийн техник, хангамж</b>	630		
4	<b>Бизнесийн удирдлага</b> ( <i>Нягтлан бодох бүртгэл; Банкны менежмент; Санхүүгийн менежмент; Санхүү-эдийн засаг; Даатгалын эдийн засаг; Санхүүгийн менежмент-мэдээлэл зүй; Олон улсын худалдааны менежмент; Маркетингийн менежмент; Бизнесийн менежмент; Гадаад худалдаа-гаалийн менежмент</i> ) <sup>3</sup> ; <b>Эдийн засаг</b> ( <i>Эдийн засаг- статистик; Хүн ам зүй; Эдийн засаг; Олон улсын эдийн засаг; Эдийн засгийн мэдээлэл</i> ) <sup>3</sup> ; <b>Менежмент, төрийн захиргааны</b>	720		
5	<b>Худалдаа, үйлдвэрлэлийн менежмент</b> ( <i>Үйлдвэрлэлийн менежмент; Худалдааны менежмент; Ня-бо, хяналт шалгалт; Ня-бо, мэдээлэл зүй; Биржийн худалдааны менежмент</i> ) <sup>3</sup>	660		
6	<b>Электроник, автоматик ба Мультимедиа холбооны технологи</b> <sup>3</sup> ; <b>Компьютерийн техник ба Компьютерийн сүлжээ</b> <sup>3</sup>	620	Математик	Физик
7	<b>Цаг уур, ус судлал</b> ( <i>Цаг уурын мэдээлэл, прогноз; Ус судлал, усны хими</i> ) <sup>3</sup> ; <b>Одон орон судлал</b>	560		
8	<b>Физик</b> ( <i>Хатуу биеийн физик; Оптик спектр судлал; Онолын физик; Цөмийн физик</i> ) <sup>3</sup> ; <b>Радио физик</b>	560	Физик	
9	<b>Хэрэглээний физик</b> ( <i>Цөмийн технологи; Физик-электроник; Геофизик; Хэрэглээний геофизик; Сэргээгдэх эрчим хүч; Хатуу биеийн материал судлал; Цөмийн эрчим</i>	560	Физик	Математик

	хүч) <sup>3</sup> ; <b>Багш, физикийн</b>			
10	<b>Хими</b> (Хими; Хими технологи; Нефтийн хими; Хүрээлэн буй орчны хими; Хүнсний хими; Эрдэс материалын хими; Байгалийн нэгдлийн хими; Нүүрсний хими) <sup>3</sup> ; <b>Багш, химийн; Органик бус хими</b>	560	Хими	Физик/Биологи
11	<b>Биологи</b> (Биологи; Амьтан судлал; Ургамал судлал; Микробиологи; Биофизик; Биохими; Генетик, молекул биологи; Экологи, байгаль хамгаалал; Ой судлал; Биологи, биотехнологи; Биологи, хэрэглээний (Биоинформатик)) <sup>3</sup> ; <b>Багш, биологи-байгаль шинжлэлийн; Биологи (экологи)</b>	560	Биологи	Математик
12	<b>Газарзүй</b> (Газарзүй; Байгаль орчныг зайнаас тандан судлал ба газар зүйн мэдээллийн систем) <sup>3</sup> ; <b>Газар төлөвлөлт, зураглал</b> (Менежмент, газар зохион байгуулалт; Газрын кадастр; Хот ба бүс нутгийн төлөвлөлт) <sup>3</sup> ; <b>Хүрээлэн буй орчин</b> (Байгаль орчны хяналт үнэлгээ; Хүрээлэн буй орчны экологи; Байгаль орчны нөхөн сэргээлт) <sup>3</sup> ; <b>Геологи</b> (Геологи; Шатах ашигт малтмалын эрэл хайгуул; Геологи, эрдэс баялгийн менежмент) <sup>3</sup> ; <b>Багш, газар зүй-байгалийн шинжлэлийн</b>	560	Математик	Газарзүй
13	<b>Монгол хэл, уран зохиол</b> (Монгол хэл, уран зохиол; Монгол хэл, эх бичиг судлал, Утга зохиол судлал, шүүмж) <sup>3</sup> ; <b>Монгол хэл-Эх бичиг судлалын багш; Утга зохиол судлал, шүүмж</b> (Улаанбаатар сургуулийн) <sup>1</sup> ; <b>Багш, монгол хэл-уран зохиолын</b>	600	Монгол хэл	
14	<b>Урлаг судлал</b> <sup>1</sup>	560		
15	<b>Судлал, монгол-англи хэл; Судлал, монгол-хятад хэл; Судлал, монгол-япон хэл; Судлал, монгол-солонгос хэл</b>	590	Монгол хэл	Англи/Орос хэл
16	<b>Сэтгүүл зүй</b> <sup>1</sup> (Сэтгүүл зүй; Олон улсын сэтгүүл зүй) <sup>3</sup> ; <b>Англи хэл-сэтгүүл зүй</b> <sup>1</sup>	610		
17	<b>Олон улс судлал, англи-америк</b> <sup>2</sup> ; <b>Олон улс судлал, герман</b> <sup>2</sup> ; <b>Олон улс судлал, франц</b> <sup>2</sup> ; <b>Олон улс судлал, орос</b> <sup>2</sup> ; <b>Олон улс судлал, хятад</b> <sup>2</sup> ; <b>Олон улс судлал, япон</b> <sup>2</sup> ; <b>Олон улс судлал, солонгос</b> <sup>2</sup> ; <b>Олон улс судлал, турк</b> <sup>2</sup> ; <b>Орчуулга, гадаад хэлний /япон/</b> <sup>2</sup> ; <b>Орчуулга, гадаад хэлний /солонгос/</b> <sup>2</sup> ; <b>Орчуулга, гадаад хэлний /хятад/</b> <sup>2</sup>	660/560	Англи/Орос хэл	
18	<b>Түүх, археологи</b> (Түүх; Археологи; Археологи-антропологи; Нийгэм, соёлын антропологи) <sup>3</sup> ; <b>Багш, түүх-нийгэм судлалын; Түүх-археологи</b>	560	Монголын түүх	

19	<b>Археологи-хятад судлал; Археологи-япон судлал; Археологи-солонгос судлал; Түүх-хятад судлал; Түүх-япон судлал; Түүх-солонгос судлал</b>	560	Монголын түүх	Англи/Орос хэл
20	<b>Социологи; Гүн ухаан; Шашин судлал (Шашин судлал; Буддын гүн ухаан)<sup>3</sup>; Улс төр судлал; Сэтгэл судлал; Нийгмийн ажил; Багш, гүн ухааны</b>	610	Нийгмийн тухай мэдлэг	Англи/Орос хэл
21	<b>Эрх зүй (Эрх зүй; Эрх зүй, олон улсын)<sup>3</sup>; Бизнесийн эрх зүй</b>	680	Нийгмийн тухай мэдлэг	Математик
22	<b>Олон улсын харилцаа</b>	660	Англи хэл	Монголын түүх
23	<b>Олон улсын эдийн засгийн харилцаа</b>	660	Математик	Англи хэл
24	<b>Зочид буудал, зоогийн газрын менежмент; Реклам сурталчилгааны менежмент<sup>1</sup>; Менежмент, аялал жуулчлалын</b>	580		
25	<b>Бизнесийн сэтгэл судлал; Менежмент, нутгийн удирдлага</b>	560	Математик	Нийгмийн тухай мэдлэг

**Тайлбар:**

<sup>1)</sup> Энд заасан ЕШ-аас гадна нэмэлт ур чадварын шалгалт өгнө (Энэ журмын 4.5-р заалтыг үз). Шалгалтын цагийг бүртгэлийн үед мэдэгдэнэ.

<sup>2)</sup> 17-р бүлгээр элсүүлэх хяналтын тоог англи, орос хэлээр ЕШ өгсөн нийт хүмүүсийн тоо, тус бүлэгт бүртгүүлэгчдийн тооны харьцаанд үндэслэн хуваарилах ба бүртгүүлэгчдэд тухайн үед нь танилцуулна.

<sup>3)</sup> Налуу үсгээр бичсэн хөтөлбөрүүдийн мэргэжлийн суурь ижил тул эдгээр хөтөлбөрт элсэхийг хүсвэл өмнө нь бичсэн ерөнхий нэрээр бүлэг хөтөлбөр сонгон элсч, МУИС-ийн бакалаврын сургалтын журамд заасны дагуу суралцах явцдаа мэргэших үндсэн чиглэлээ сонгон суралцана. Жишээ нь, 4-р бүлэг дэх Эдийн засаг (Эдийн засаг, статистик; Хүн ам зүй; Эдийн засаг; Олон улсын эдийн засаг; Эдийн засгийн мэдээлэл) гэсэн бүлэг мэргэжлийг сонгосон элсэгч суралцах явцдаа хаалтан доторх мэргэжлүүдээс сонгон мэргэшинэ.